



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/535

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны төсөв нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай” 7/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Вьетнам улсын Хо Ши Мин хотод таеквондогийн өсвөрийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох Гантөмөрийн Азжаргал, Пүрэвжалын Удвал нарт сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор 6,000,000 төгрөгийн дэмжлэгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дэмжлэгт зарцуулагдах 6,000,000 төгрөг (Зургаан сая)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.2-д тусгагдсан “Чадварлаг багш, сурагч, оюутан” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Энхболд)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2653
Zah A/535 Bo

Аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 16-ны өдрийн
А/535 дугаар захирамжийн хансралт



ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

Д/д	Оролцох сурагч	Оролцох жин кг	Үзүүлэх дэмжлэг	Нийт үнэ
1	П.Удвал	68	3 000 000	3 000 000
2	Г.Азжаргал	+68	3 000 000	3 000 000
Нийт				6 000 000

-oOo-